



## ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

### БАНКНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Банкны салбарын нийт активын хэмжээ 2011 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 8.2 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас 0.9 их наяд төгрөгөөр буюу 1.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөгөөр буюу 49.5 хувиар өслөө. Банкуудын эх үүсвэрийн өсөлт тогтмол хадгалагдаж байгаа нь активын өсөлтөд нөлөөлсөөр байна. Нийт зээлийн хэмжээ 5.0 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас 165.3 тэрбум төгрөгөөр буюу 3.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буюу 61.2 хувиар нэмэгдлээ. Нийт зээлийн багцын 94.5 хувийг хэвийн, 1.5 хувийг хугацаа хэтэрсэн, 4.0 хувийг чанаргүй зээл эзэлж байгаа бөгөөд банкны системийн хэмжээгээр 201.5 тэрбум төгрөгийн хэмжээтэй байна.

Банкуудын ашигт ажиллагаа сайжирсаар байгаа ба төгрөгийн зээлийн хүү 2011 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 15.9 хувьд хүрсэн нь оны эхнээс 2.5 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 3.6 нэгжээр буурсан бол валютын зээлийн хүүгийн хэмжээ оны эхнээс 0.8 нэгжээр өсч, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр буурчээ.

Хөрвөх чадвар бүхий активын хэмжээ 2.9 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас 80.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Хөрвөх активын хэмжээ буурч байгаа нь банкуудын зээл олголт нэмэгдэж байгаатай холбоотой байна. Мөнгөн хөрөнгийн хэмжээ 1.7 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас 91.4 тэрбум төгрөгөөр өссөн бол богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 0.8 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас 172.1 тэрбум төгрөгөөр буурлаа.

Харилцах 2.1 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас 4.4 тэрбум төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан бол хадгаламж 3.8 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас 34.1 тэрбум төгрөгөөр буюу 0.9 хувиар өсчээ. Нийт хадгаламжийн 70.5 хувийг хугацаатай хадгаламж эзэлж байгаа бол үлдэх 20.5 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна. Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүүгийн хэмжээ оны эхэнтэй харьцуулахад буурч байгаа хэдий ч банкуудын хадгаламжийн өсөлт тогтвортой байна.

Банкны салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 830.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх сараас 10.2 тэрбум төгрөгөөр буюу 1.2 хувиар өслөө. Банкуудын ашигт ажиллагаа нэмэгдэж байгаа нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байгаа бөгөөд банкны салбар оны эхний 10 сард 134.1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ,

Банкны эрсдэл даах чадварыг илэрхийлэгч өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын харьцаа 14 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон доод хэмжээнээс 2 нэгж хувиар өндөр байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд Зээлийн мэдээллийн тухай хуулийг УИХ-аар батлуулаад байгаа бол Хадгаламжийн даатгалын хуулийн төслийг УИХ-д өргөн барьж батлуулахаар бэлдэж байна. Мөн түүнчлэн банкны тухай хууль шинэчлэн найруулагдаж батлагдсантай холбоотойгоор холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Үүнээс гадна банкны эрсдлийн удирдлага, компанийн засаглалыг сайжруулах, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл, хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, банкны эрсдэл даах чадварыг сайжруулах, нягтлан бодох

бүртгэлийн бодлогод олон улсын стандартын хүрээнд шинэчлэлт хийх, банкуудад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр 2012 оны мөнгөний бодлогын чиглэлд тусгагдсан болно.

## **ГАДААД СЕКТОР**

### **I. Төлбөрийн тэнцэл [2011 оны эхний 3 улиралд]**

Урсгал тэнцлийн алдагдал **1.7** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **4.1** дахин өсөөд байна. Урсгал тэнцлийн алдагдал ийнхүү огцом өсөхөд барааны гадаад худалдааны алдагдал **4.4** дахин, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал **5.1** дахин, цэвэр орлогын дансны алдагдал **1.5** дахин өссөн нь нөлөөлжээ. Гэвч хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг **2.0** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **3.2** дахин өслөө. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр **2.6** тэрбум ам.долларт хүрч **2.5** дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Хэдийгээр урсгал тэнцэл алдагдалтай байгаа хэдий ч, түүнийг хөрөнгө ба санхүүгийн дансны ашгаар бүрэн санхүүжүүлж байгаа хандлага хэвээр байна. Ингэснээр Монгол Улсын төлбөрийн тэнцэл оны эхний гурван улиралд **217** сая ам.долларын ашигтай гарлаа.

### **II. Валютын урсгал [2011 оны эхнээс 11 дүгээр сарын 22-ныг дуусталх хугацаанд]**

Валютын урсгалын нийт эргэлт өнгөрсөн оны мөн үеэс **1.6** дахин өсчээ. Үүний дотор валютын нийт орох урсгал **47** хувиар, харин гарах урсгал **73** хувиар тус тус өссөн байна. Ингэснээр валютын цэвэр орох урсгалын хэмжээ **437** сая ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрсэн нь өнгөрсөн оноос **61** хувиар буурсан үзүүлэлт юм. Гэвч ам.доллар болон юанийн цэвэр орох урсгалын хэмжээ харгалзан **908** сая, **330** сая ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрснээс үзэхэд Монгол Улсын эдийн засагт цэвэр дүнгээр валютын орох урсгал давамгайлсан хэвээр байгаа юм.

### **III. Гадаад худалдаа [2011 оны эхний 10 сард]**

Гадаад худалдааны нийт бараа эргэлт **9.1** тэрбум ам.долларт хүрч **90** хувиар өссөний дотор экспорт **67** хувиар өсч **3.8** тэрбум ам.долларт, импорт **111** хувиар өсч **5.4** тэрбум ам.долларт хүрээд байна. Барааны гадаад худалдааны тэнцэл **1.6** тэрбум ам.долларын алдагдалтай болж өнгөрсөн оны мөн үеэс **6.1** дахин, валютаар төлбөр нь хийгддэг барааны гадаад худалдааны алдагдал **441** сая ам.долларт хүрч **8.8** дахин өсчээ. Нийт экспортын **74** хувийг нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр бүрдүүлж байгаа бол нийт импортын **51** хувийг хүнд машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна.

### **IV. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш [2011 оны эхнээс 11 дүгээр сарын 22-ныг дуусталх хугацаанд]**

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш оны эхнээс **4.9** хувиар суларсан байна. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл **0.24** хувь байгаагаас үзэхэд валютын дотоодын зах тогтвортой хэвээр байна.

**МОНГОЛБАНК**